



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 08 сарын 13 өдөр

Дугаар А/165

Арвайхээр

Үнэлгээний хороо байгуулах
тухай

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 47.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр Арвайхээр сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн үдийн цайнд бүтээгдэхүүн нийлүүлэх аж ахуй нэгж, байгууллагыг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Б.Ариунцэцэг /Мал эмнэлэг үржлийн тасгийн дарга, Мал эмнэлэг хүнс худалдааны хяналтын улсын байцаагч/

Нарийн бичгийн дарга: Д.Балжинням /2 дугаар сургуулийн сургалтын менежер/

Гишүүд: Ц.Төмөрбаатар /Хотын Захирагчийн албаны Ерөнхий менежер/

Х.Нарантуяа /2 дугаар сургуулийн сургалтын менежер/

С.Чинбат /Төрийн бус байгууллагын төлөөлөл/

Д.Өлзийхишигт /Иргэний төлөөлөл/

Б.Золбоо /Иргэний төлөөлөл/

2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг цахим хэлбэрээр холбогдох хууль тогтоомж, заавар журмын дагуу үр дүнтэй зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга Мал эмнэлэг үржлийн тасгийн дарга, Мал эмнэлэг хүнс худалдааны хяналтын улсын байцаагч (Б.Ариунцэцэг), үнэлгээний хорооны гишүүдэд тус тус даалгасугай.

ДАРГА



О.ПҮРЭВДОРЖ

371100329